

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОЛИМП, НИЙТИЙН БИЕЙН ТАМИР,
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГАТАЙ 2024 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН
АЖЛЫН ТАЙЛАН**

2024 оны 12 дүгээр сарын 05

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны даргатай аймгийн Засаг даргын байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт зөвлөмж гаргах, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг сайжруулж, цаашид гарах үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны даргатай байгуулсан аймгийн Засаг даргын хамтран ажиллах гэрээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан“ Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан арга зүйгээр Нийгмийн бодлогын хэлтсээс ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны салбарт 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг дарга хамтран ажиллах гэрээгээр 16 үүргийг хүлээж орон нутагт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Эхний хагас жилд 16 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 93,1 хувьтай үнэлэгдсэн бөгөөд жилийн эцсийн байдлаар 96.9 хувьтай хэрэгжүүлсэн байна. Эхний хагас жилтэй харьцуулахад хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган үр дүнг тооцож ажилласаны үр дүнд жилийн эцсээр 3,8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ОНЦЛОХ АЖЛУУД:

2.2.2. Зуун буудалт даамын улсын аварга шалгаруулах тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.

Монгол улсын зуун буудалт даамын эрэгтэй 47 дахь, эмэгтэй 34 дэх удаагийн улсын аваргын тэмцээн Дундговь аймгийн Мандалговь хотноо тавдугаар сарын 6 -аас 13 -ны хооронд боллоо.

Улсын аварга шалгаруулах тэмцээнд 10-62 насны эрэгтэй 14, эмэгтэй 12 тамирчин оролцсоноос Олон Улсын их мастер 3, Олон Улсын мастер 1, Дэлхийн даамын холбооны мастер 5, Дэлхийн даамын холбооны дэд мастер 2, Монгол Улсын спортын мастер 11, Дэд мастер 3 оролцсон нь онцлог байсан юм.

Мөн тус тэмцээнд Эрдэнэболдын Ану 9 оноо авч Спортын Мастерын 1 баллын болзолыг хангасан амжилт үзүүллээ.



Улсын аварга шалгаруулах шугаман бүжгийн анхдугаар тэмцээнд 50+ насны ангилалын шилдэгт шалгарлаа.

Дундговь аймгийн Б.Наранхүү ахлагчтай "Говийн наран" бүжгийн клубийн "Говийн жавхаа-2" хамтлаг "Монголын шугаман бүжгийн холбоо"-оос зохион байгуулсан шугаман бүжгийн Улсын аварга шалгаруулах анхдугаар их наадамд оролцон 50+ насны ангилалд 39 баг тамирчдаас шилдэг 9 номинацид шалгаран, цомын эзэд боллоо.

Улсын аварга шалгаруулах тэмцээнд шаардлагатай 2,4 сая төгрөгийн дэмжлэгийг Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас шийдвэрлэсэн юм.



Абу Даби хотноо зохион байгуулагдсан бүсний ангилалтай Залуучуудын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээний шар бүсний -44 кг жинд Дундговь аймгийн Харцага клуб, Ид шидийн орон Дундговь төвийн тамирчин Х.Пүрэвдэлгэр дасгалжуулагчтай Мөнхбатын Эрхсаран хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн.



БНСУ-ын Seongnam хотноо 7-р сарын 20-21 өдрүүдэд зохион байгуулагдсан “Seongnam Open International Taekwondo Championship 2024” тэмцээнд 21 орны 6000 гаруй тамирчид хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс: Хурдан өшиглөлтийн төрөлд:Ц.Дэжидмаа хүрэл медаль, Э.Гэгээнээ-хүрэл медаль, Тулааны төрөлд:Ц.Дэжидмаа 43кг-д мөнгөн медаль, Э.Гэгээнээ 40кг-д хүрэл медалийн болзол хангаж амжилттай оролцлоо.



2.2.6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар зохион байгуулагдсан "Эерэг хандлага –Эрүүл Монгол" аяны хүрээнд, "Эрүүл чийрэг - Дундговьчууд" аяныг 2024 оны 04 дүгээр сарын 01-нээс 30-ны өдрүүдэд өглөөний 06:30-07:30 цагийн хооронд Биеийн тамир, спортын газрын зааланд зохион байгууллаа. Тус аяны хүрээнд Эрүүл мэндийн газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний төв, "Алтан өргөө" бүжгийн клуб, "Говийн наран" бүжгийн клуб, Иогийн сургалтууд, "Шонхор" фитнес клубууд хамтран ажиллалаа. 4 дүгээр сард зарласан аяны хүрээнд нийт 5514 иргэн хамрагдсан бөгөөд тус аяныг 12 дугаар сарын 01-нээс дахин эхлүүлээд байна.





2.2.10. 2024 онд Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд нийт 7539 иргэн хамрагдсанаас А,В,С үнэлгээтэй 3482 иргэн хамрагдсан бөгөөд А үнэлгээтэй 393, В үнэлгээтэй 1289 иргэн, С үнэлгээтэй 1800 иргэн байна.



2.2.11. Өвлийн үндэсний спортыг хөгжүүлэх зорилгоор Аймгийн аварга шалгаруулах “Мөсөн сурын харваа” тэмцээнийг амжилттай зохион байгууллаа. Тус тэмцээнд 50 гаруй тамирчин өрсөлдөж цэц мэргэнээ сорьсон юм.

Мөсөн сурын харваа тэмцээнийг зохион байгуулснаар энэ төрлийн спортоор хичээлэх хүсэл сохирхолтой иргэд нэмэгдэх ач тустай хэмээн тэмцээнд оролцогчид онцлон, тус тэмцээнийг уламжлал болгон зохион байгуулах нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байсан юм.





Монгол үндэсний уламжлалт спортыг өвлүүлэн уламжлуулах ажлын хүрээнд Үндэсний сурын харваа тэмцээнийг 3 удаа, өвлийн харваа тэмцээнийг 1 удаа, үндэсний бөхийн барилдааныг 3 удаа, үндэсний шагайн харваа тэмцээнийг 3 удаа, Хаврын бүсийн морин уралдаан 1 удаа тус тус зохион байгуулсан.

Мөн хүүхэд багачуудын дунд үндэсний спортыг хөгжүүлэх, өвлүүлэн уламжлуулах зорилгоор Олон Улсын хүний эрхийг хамгаалах өдөр буюу 06 дугаар сарын 01-нд цэцэрлэгийн насны хүүхдүүдийн дунд “Хуйрнан шуугчигч” бөхийн барилдаан, сургуулийн насны хүүхдүүдийн дунд анх удаа “Үндэсний шагай”-н харваа тэмцээнийг зохион байгуулсан нь хүүхэд багачууд үндэсний спортоор хичээлэх хүсэл сонирхолтой болж үндэсний спортоор хичээлэгчдийн тоо 77-оор нэмэгдсэн байна.





2.2.13. Усан бассейн бүхий спорт цогцолборын ажлыг 2024 онд улсын төсвийн дөрвөн тэр бум наян хоёр /4.82.0/ сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын гүйцэтгэлийг “Жи жи ай” ХХКомпани хоёр давхрын карказ, суурийн дүүргэлт зэрэг ажлыг хийж гүйцэтгээд байна. 2024 онд тус барилгын явцад 2 удаа хяналт тавьж ажилласан. 2024 онд барилгын гүйцэтгэлийн ажил 77 хувьд хүрсэн байна.



ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Биеийн тамир, спортын салбарын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг 96,9 хувь буюу “Тодорхой үр дүнд” хүрсэн гэж үнэлж үнэлгээний саналыг хүргүүлж байна. Гэрээний үүргийг орон нутагт хэрэгжүүлэхэд нийт 139.4 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулснаас улсын төсвөөс 37.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 101.5 сая төгрөгийг зарцуулж гэрээгээр хүлээсэн үүргийг үр дүнтэй хэрэгжүүлсэн гэж дүгнэлээ. Төрийн зарим чиг үүргийг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэлийг баримтлан ажиллаж, спортын 17 холбоодтой хамтран, аймаг бүс, Улсын аварга шалгаруулах 45 уралдаан тэмцээнийг зохион байгуулж, нийт 13587 иргэдийг хамруулан 31.6 сая төгрөгийг зарцуулсан.

“Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, залуу хойч үедээ өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, тив, дэлхий, олон улс, улсын чанартай спортын уралдаан, тэмцээнд оролцох тамирчдад дэмжлэг үзүүлэн урамшуулах чиглэлээр эхний хагас жилд 126 тамирчин 18 багш дасгалжуулагч 29.08 сая төгрөг, сүүлийн хагас жилд 42 тамирчин 8 багшид 17.66 сая төгрөг нийт 46.74 сая төгрөгийг Аймгийн Засаг даргын 2024 оны А/522 дугаар захирамжаар батлагдсан “Дундговь аймгийн Засаг даргын шагнал олгох журам”-ын дагуу Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлүүлэн зарцуулсан байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар зохион байгуулагдсан “Эерэг хандлага-Эрүүл Монгол” аяны хүрээнд, “Эрүүл чийрэг-Дундговьчууд” аян, Шонхор фитнес клубээс “эрүүл, эртэч, эерэг гэр бүл” аян, “Биеийн тамир, спортын бүтээлч сар-2024” томоохон арга хэмжээнүүдийг олон нийтийн оролцоог хангах, спортыг хөгжүүлэн сурталчлан таниулах, иргэдэд эрүүл аж төрөх дадлыг бий болгох зорилготойгоор зохион байгуулсан. Эдгээр арга хэмжээг зохион байгуулснаар нийтийн биеийн тамир болон спортын төрлөөр хичээллэх нийт иргэдийн тоо 35020-д хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4482 тогтмол хичээллэгч иргэнээр нэмэгдсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж иргэдийг хамруулах, шинэ тогтолцоог бий болгоход хамтран ажилласан. Сорилд нийт 7539 иргэн хамрагдсанаас А,В,С үнэлгээтэй 3482 иргэн хамрагдсан бөгөөд А үнэлгээтэй 393, В үнэлгээтэй 1289 иргэн, С үнэлгээтэй 1800 иргэн хамрагдсан байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Нийгмийн бодлогын хэлтэст:

1.Гэрээнд тусгагдсан үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхдөө суурь түвшин, хүрэх түвшин бодитой статистик тоон судалгаанд үндэслэн тодорхойлох.

2.Гэрээний хэрэгжилтийн тайланг ирүүлэхдээ шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшиндээ хүрсэн эсэх гарсан эцсийн үр дүн, үр нөлөөг тайлагнаж байх

3. Сумдад орон тооны биеийн тамирын арга зүйч нарыг ажиллуулах талаар чиглэл хүргүүлж хамтарч ажиллах

БАТАЛГААЖУУЛСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

С.МӨНХЧУЛУУН

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

ДАРГА

Д.ДААРИЙМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Л.МЯГМАРМЯДАГ